

ИНФЛЯЦИЙН  
ХҮЛЭЭЛТИЙН  
ТҮҮВЭР  
СУДАЛГАА




2012 ОНЫ 1 САР

МӨНГӨНИЙ БОДЛОГО, СУДАЛГААНЫ ГАЗАР  
СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

## ТОВЧ ХУРААНГУЙ

- Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2012 оны 1-р сард Улаанбаатар хотын 1036 иргэд, 404 аж ахуй нэгж болон 10 шинжээчдийг хамруулан явууллаа;
- Иргэдийн инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлагыг чиглэлийн индекс тооцоолон харахад **иргэдийн инфляцийн хүлээлт өсч** хэт өндөр түвшинд ойртсон байна.
- Иргэд инфляцийг 2012 оны 1-р улирлын эцэст 16.9% болж, хагас жилийн эцсээр 13.3%, оны эцсээр **13.2%** байна гэж хүлээж байна.
- ААН-үүд инфляцийг 2012 оны 1-р улирлын эцэст 8.9% болж, хагас жилийн эцсээр болон оны эцсээр **7.9%** болж буурна гэж хүлээж байна.
- Судлаачдын таамгаар инфляци 2012 оны 1-р улирлын эцэст 12.4% болж, хагас жилийн эцсээр 12.6%, оны эцсээр **13.1%** болж өснө гэж хүлээж байна.

**Зураг 1 Иргэд, ААН-ийн хүлээгдэж инфляци болон судлаачдын инфляцийн дундаж таамаглал**



Сүүдэртсэн хэсэг: иргэд, аж ахуйн нэгжийн хүлээгдэж буй инфляцийн түвшин болон судлаачдын инфляцийн таамгийг илтгэнэ

- Иргэдийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад оны эхний саруудад иргэдийн хүлээлт өндөр байгаа бөгөөд 2011 оноос хойшхи хүлээлт улирлын хэлбэлзэлтэй байгаа нь ажиглагдаж байна.
- Ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү өснө, төгрөгийн ханш суларна гэсэн иргэдийн хүлээлт өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал эрс өсчээ.
- Ирэх 12 сард хадгаламжинд мөнгөө байршуулахад тохиромжгүй гэсэн иргэдийн хүлээлт өсөх хандлагатай болсон байна.
- Судалгаанд оролцогчдын 4 хүн тутмын нэг нь ирэх 12 сард өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн бөгөөд гол шалтгаан нь цалин болон бизнесийн орлого өснө гэсэн хүлээлттэй байна.
- ААН-үүдийн тал хувь нь ирэх 6 сард ажилчдынхаа цалинг нэмэгдүүлнэ гэсэн бөгөөд эдгээрээс 48% нь 10 хүртэл хувиар, 32% нь 11-20 хувиар, 20% нь 21-30 хувиар нэмэгдүүлнэ гэжээ.
- ААН-үүдийн 60% нь ирэх 6 сард компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд тэдгээрийн 40% нь банкны зээлээр санхүүжих бол мөн 40% нь өөрийн хөрөнгөөр санхүүжихээр төлөвлөж байна.
- Шинжээчид оны эцэст төгрөгийн ам.доллар, юаньтай харьцах ханш чангарна, ДНБ өсөлт дунджаар 20%-д хүрнэ, нэрлэсэн цалин мөн өснө гэсэн таамаглалуудыг хийсэн байна.


## 1. ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1036 иргэдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгож хамрууллаа. Судалгааны үр дүнгээр иргэд инфляцийг 2012 оны 1-р улирлын эцэст **16.9%**, хагас жилийн эцэст **13.3%**, жилийн эцэст **13.2%** байхаар хүлээж байна. Мөн үнийн өсөлтийг тодорхой тоон заагаас асуухад иргэдийн инфляцийг жилийн дараа **11.2%** байхаар хүлээж байна.

### Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Насны бүтцийг харвал судалгаанд оролцогчдын 53.2% нь 25-44 насны;
- Боловсролын түвшингээр авч үзвэл 86.7% нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 81.9% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 47.2% нь хувийн салбарт ажилладаг, 17.5% нь төрийн албанд, 27.3% нь ажилгүй;
- Өрхийн орлогын зүгээс харвал 60.3% нь 200-400 мянган төгрөгийн орлоготой, 12.9% нь 200 мянгаас бага, 12.4% нь 600-800 мянга, 14.4% нь 800 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байлаа.


Зураг 1.1 Инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс (ирэх 12 сард)



Санамж: Чиглэлийн индекс нь (-1;3) завсарт утгаа авна. Нэмэх чиглэл руу хүлээлтийн хандлага өссөн, хасах чиглэл руу инфляцийн хүлээлтийн хандлага буурсан байгааг илтгэнэ.

Зураг 1.2 Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?

- 1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө
- 2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй
- 3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна
- 4. Үнэ өөрчлөгдөхгүй
- 5. Үнэ буурна
- 6. Мэдэхгүй



### 1. Хүлээлтийн ерөнхий хандлага

Чиглэлийн индекс нь иргэдийн инфляцийн хүлээлтийн хандлагыг харуулдаг бөгөөд индексийн утга ихсэх нь хүлээлтийн түвшин ихсэж байгааг, эсрэгээрээ буурвал хүлээлт намжиж байгааг илтгэнэ. Харин индексийн утга 2 гэсэн хязгаарын шугамыг давбал хүлээлтийн түвшин хэт өндөр байгааг харуулна. Зураг 1.1-ээс харахад иргэдийн хүлээлт 2010-12 оны 1-р саруудад үргэлж өсч байсан бөгөөд мөн 2011 оны 6-р сард хязгаарын шугамыг давж байжээ. Эндээс **оны эхний саруудад иргэдийн хүлээлт өндөр байдаг** гэсэн дүгнэлт хийж болхоор байна. Хүлээлтийн судалгааг 2011 оноос улирлын давтамжтай явуулж эхэлснээс харвал **иргэдийн хүлээлт улирлын хэлбэлзэлтэй** байгаа нь ажиглагдаж байна.


Хүлээлтийн чанарын хариултаас харвал нийт иргэдийн 79% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд *үнийн түвшин хурдацтайгаар өснө* гэж 38% нь хариулсан нь 2011 оны 3 болон 6-р саруудын өндөр хүлээлттэй байсан үеийнх рүү дөхөж очсон байна.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу.


**Зураг 2.1 Иргэдэд мэдрэгдсэн инфляцийн түвшин (өнгөрсөн 12 сард)**



**Зураг 2.2 Инфляцийн хүлээлтийн түвшин (ирэх 12 сард)**



**Зураг 3.1 Хүлээлтийн түвшин, тоон хариулт /ирэх 12 сарын хугацаанд/**



## 2. Инфляцийн хүлээлт болон мэдрэгдсэн инфляцийн түвшин

Иргэдийн өгсөн чанарын хариултуудыг ашиглан Карлсон-Паркин нарын магадлалын аргаар<sup>2</sup> өнгөрсөн 12 сард иргэдэд *мэдрэгдсэн инфляцийн түвшин* болон ирэх 12 сарын дараах *хүлээгдэж буй инфляцийн түвшинг* тооцооллоо.<sup>3</sup>

Зураг 2.1-ээс харахад иргэдэд мэдрэгдсэн инфляцийн түвшин хугацааны турш тогтмол буурах хандлагатай байсан бөгөөд сүүлийн судалгааны дүнгээр мэдрэгдсэн инфляцийн түвшин 6.5%-тай гарсан нь мөн хугацааны албан инфляцийн түвшнээс 4.6 нэгж хувиар бага гарчээ. Өөрөөр хэлбэл иргэд өнгөрсөн 12 сард үнийн өсөлтийг албан инфляцийн түвшингээс багаар мэдэрчээ.

Өнгөрсөн хугацааны *мэдрэгдсэн инфляцийн түвшинг* суурь болгон инфляцийн хүлээлтийг тооцоолохыг **субъектив хүлээлт** гэдэг бол албан инфляцийн түвшинг суурь болгон тооцоолохыг **объектив хүлээлт** гэнэ. Зураг 2.2-оос харахад объектив аргачлалаар тооцоолсон хүлээлт нь сүүлийн судалгааны дүнгээр нилээд өссөн бөгөөд иргэд 12 сарын дараа инфляцийг одоогийн түвшнээс өсч **13.2%** байхаар хүлээж байна. Мөн субъектив аргачлалаар тооцоолсон хүлээлт нь иргэдийн мэдэрсэн инфляцийн түвшнээс өсч **7.8%** байхаар хүлээгдэж байна. Эндээс 12 сарын дараах иргэдийн инфляцийн хүлээлт объектив, субъектив аль аль хандлагаар өссөн байгаа нь харагдаж байна. Объектив болон субъектив хүлээлтийн зөрүүтэй байдал нь мэдрэгдсэн инфляци болон албан инфляцийн зөрүүтэй байдлаар тайлбарлагдах юм.

## 3. Инфляцийн хүлээлтийн тоон хариулт


Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. Зураг 3.1-ээс харахад судалгаанд оролцсон иргэдийн 37% нь инфляцийг 12 сарын дараа 9-11%-д, 26% нь 11-13%-д, 10% нь 7-9%-д байна гэж үзсэн

<sup>2</sup> Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Econometrica" 42, pp. 123-38.

<sup>3</sup> Дэлгэрэнгүйг "Инфляцийн хүлээлтийг тооцоолох арга, аргачлалыг боловсронгуй болгох нь: Монголын жишээ" (С.Билүүн, 2011) ажлаас харна уу.

бөгөөд иргэдийн тоон хариултуудын дундаж утга буюу иргэд 12 сарын дараа инфляцийг **11.2%** байна гэж хүлээж байна.

**Зураг 4.1** Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн харьцуулалт




**4. Жилийн эцсийн хүлээлт**

2012 оны жилийн эцсийн хүлээлтийг харьцуулан харвал хамгийн өндөр буюу объектив хүлээлт 13.2%, шууд тоон хариултаар авсан хариулт 11.2%, харин субъектив хүлээлт 7.8% байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлд 2012 оны эцэст ХҮИ-ээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тоонд байлгана гэсэн зорилтыг тавиад байгаа билээ. Мөн олон улсын валютын сангийн таамаглалаас харахад 2012 оны эцэст инфляци 9.3%-тай байна .

**5. Бусад асуултуудын дүн**

Судалгаанд оролцогчдын **44.5% нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өснө** гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгүүдээс огцом өссөн үзүүлэлт байна. Харин эсрэгээрээ зээлийн хүү буурна гэсэн хариулт огцом буурч 6% болж, зээлийн хүү хэвэндээ байна гэсэн хариулт бага зэрэг багасч 23.5%-д хүрчээ.

**Зураг 5.1** Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?




Иргэдийн зээлийн хүүний талаарх хандлагын чиглэлийн индексийг харвал 2008 оноос 2010 оны 7 сарын судалгааны дүнгээр иргэд ирэх 12 сард зээлийн хүү одоогийнхоос ерөнхийдөө өснө гэсэн хандлагатай байсан боловч уг хандлага нь бага багаар буурсаар 2011 оны 1 сарын судалгааны дүнгээр хэвэндээ байна, 3-р сард зээлийн хүүг буурна гэсэн хандлагатай болжээ. Харин 6-р сараас эхлэн зээлийн хүүний хандлага өсч сүүлийн судалгааны дүнгээр иргэдийн дийлэнх нь ирэх 12 сард зээлийн хүүг одоогийнхоос өснө гэж үзсэн байна. Банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүүний түвшинг харахад 2011 оны эцсээр буурах хандлагатай байгаа ч иргэд үүний эсрэгээр зээлийн хүүний түвшинг өснө гэж үзжээ. Монголбанк 2012 онд төсвийн хэт тэлсэн бодлогын эсрэг мөнгөний хатуу бодлого баримтлахаар олон нийтэд зарласан нь зээлийн хүүний хүлээлт өсөхөд нөлөөлсөн байж болох юм.

**Зураг 5.1.а** Зээлийн хүүний чиглэлийн индекс ба зээлийн хүү




Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] завсарт утгаа авбал хүү өснө, [0] дээр утга авбал хэвэндээ байна, [0;-1] завсарт утгаа авбал буурна гэсэн утгыг илэрхийлнэ.

**Зураг 5.2 Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?**



Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү нь буюу 52% нь ирэх 12 сард **төгрөгийн бусад валюттай харьцах ханш суларна** гэж үзсэн байгаа нь өмнөх судалгаануудын дүнгээс эрс өссөн үзүүлэлт байна. Харин төгрөгийн ханш хэвэндээ байна гэсэн хариултын хувь буурч 24% болсон бол чангарна гэсэн хариултын хувь тогтмол байна.


**Зураг 5.2.а Төгрөгийн ханшийн чиглэлийн индекс ба төгрөгийн ханшийн жилийн өөрчлөлт**



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;1] завсарт утгаа авна. [0;1] завсарт утгаа авбал ханш суларна, [0] дээр утга авбал хэвэндээ байна, [0;-1] завсарт утгаа авбал чангарна гэсэн утгыг илэрхийлнэ.

Иргэдийн төгрөгийн ханшийн хүлээлтийн чиглэлийн индексийг харвал иргэд 2011 оны эхэнд хийсэн судалгаагаар ханш ирэх 12 сард чангарна гэж үзэж байсан бол 3-р сарын судалгаанаас энэ хандлага буурсаар сүүлийн судалгааны дүнгээр дийлэнх нь ханш суларна гэсэн хандлагатай болжээ. Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханшийн тоон мэдээнээс харвал 2011 оны сүүлээр мөн сулрах хандлагатай болсон бөгөөд өмнөх сартай харьцуулбал 3.8%-иар, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.4%-иар суларсан байна.

**Зураг 5.3 Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?**




Судалгаанд оролцогчдын 40% гаруй нь ирэх 12 сард **хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжгүй** үе гэж үзэж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад огцом өсч, харин тохиромжтой гэсэн хариулт буурч 21%-д, **мэдэхгүй** гэсэн хариулт мөн буурч 38%-д хүрсэн байна.

2011 оны эцсийн байдлаар хадгаламжийн бодит хүү сөрөг<sup>4</sup> түвшинд очсон бөгөөд төгрөгийн хадгаламж болон нийт хадгаламжийн өсөлтийн хурдац<sup>5</sup> 2011 оны сүүлийн улиралд буурах хандлага үргэлжилсээр байгаа нь судалгааны ирэх 12 сард хадгаламж хийхэд тохиромжгүй үе гэсэн хариултын хувь нэмэгдсэнтэй нийцэж байна.


<sup>4</sup> 2011 оны 12 сарын эцсийн байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс Улаанбаатарын инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү -0.6% байна.

<sup>5</sup> 2011 оны 10-12 сарын хооронд нийт хадгаламжийн жилийн өсөлт 62.5-41.1%, төгрөгийн хадгаламжийнх 71.7-45.5% болж буурсан байна.

**Зураг 5.4 Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?**



**Зураг 5.4.а Өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индекс**



Санамж: Чиглэлийн индекс нь [-1;-1] завсарт утгаа авна. [0;1] завсарт утгаа авбал өрхийн санхүүгийн байдал өснө, [0] дээр утга авбал хэвэндээ байна, [0;-1] муудна гэсэн утгыг илэрхийлнэ.

**Зураг 5.4.б Сайжрах бол шалтгаан нь юу вэ?**



Ирэх 12 сарын хугацаанд иргэдийн **өрхийн санхүүгийн байдал хэвэндээ байна, муудна** гэсэн хариултуудын хувь өмнөх судалгаанаас 10 нэгжээр өсч 58%-д хүрсэн бөгөөд үүнээс муудна гэсэн хариултын хувь хэмжээ 2 нэгжээр өсч 19%-д хүрсэн байна. Харин **сайжирна** гэсэн хариулт 5 нэгжээр буурч 25%-д хүрчээ.


2008 оны эцэст хийгдсэн судалгааны дүнгээр

иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал нь муудна гэж үзэх хандлагатай байсан бол 2009 оны 9-р сараас хойш хийгдсэн судалгаануудаар ирэх 12 сард ерөнхийдөө сайжирна гэж үзэх хандлагатай болсон байна. Чиглэлийн индекс 2011 оны эхнээс тогтмол өссөөр байсан ч энэ удаагийн судалгааны дүнгээр буурах хандлагатай болжээ.

Иргэдийн өрхийн санхүүгийн байдлын хүлээлтээс харахад хүлээлт муудсан үеүүдэд инфляцийн түвшин үргэлж 2 оронтой тоонд орсон байхад, хүлээлт сайжирсан үед инфляци харьцангуй доогуур түвшинд байгаа нь ажиглагдлаа.

Өрхийн санхүүгийн байдал **сайжирна** гэж судалгаанд оролцсон иргэдийн 25% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 54% нь ирэх 12 сард **цалин болон бизнесийн орлого нэмэгдэнэ** гэж үзсэн байна. Мөн 19% нь төрөөс тэтгэмж тэтгэлэг авна, 13% нь гэр бүлийн гишүүдээс ажлын байртай болсноор өрхийн санхүү дээшилнэ гэж үзсэн байна. Харин 6% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөнөөс, 4% нь хамаатан найз нараас тусламж авснаар, 3% нь үнэ буурснаар өрхийн санхүү дээшилнэ гэжээ. Татварын хөнгөлөлт хүртэнэ гэсэн хариултыг иргэд сонгоогүй байна.

Зураг 5.4.в Муудах бол шалтгаан нь юу вэ?



Өрхийн санхүүгийн байдал муудна гэж иргэдийн 19% нь хариулсан бөгөөд тэдгээрийн 42% нь ирэх 12 сарын хугацаанд үнэ өссөнөөс шалтгаалан өрхийн санхүүгийн байдал муудна гэж үзжээ. Харин 28% нь цалин болон бизнесийн орлого буурна, 10% нь төрөөс тэтгэмж тэтгэлэг авахгүй, 8% нь үл хөдлөх хөрөнгийн үнэ буурна, 6% нь өрхийн гишүүн ажилгүй болно, 3% нь бусад санхүүгийн тусламж үзүүлнэ, мөн 3% нь таварын ачаалал ихэссэнээс өрхийн санхүү муулна гэж үзсэн байна.

## ДҮГНЭЛТ

Иргэдийн инфляцийн хүлээлтийн ерөнхий хандлагыг чиглэлийн индекс болон иргэдийн чанарын хариултуудаас харахад аль аль нь хүлээлт өссөн байгааг илтгэж байна. Ялангуяа чиглэлийн индекс хязгаарын шугамтай давхцаж хүлээлт хэт өндөр түвшинд очиж буйг харууллаа. Мөн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад оны эхний саруудад иргэдийн хүлээлт өндөр байгаа бөгөөд 2011 оноос хойшхи хүлээлт улирлын хэлбэлзэлтэй байгаа нь ажиглагдаж байна.

Иргэдийн инфляцийн хүлээлтийн тоон утгуудыг харвал магадлалын аргачлалаар тооцсон объектив болон субъектив хүлээлтийн түвшин аль аль нь өсөх хандлагатай бөгөөд жилийн дараа инфляци харгалзан 13.2% болон 7.8% болно гэж хүлээж байна. Иргэдийн хүлээлтийг шууд тоон завсраас асуугаад дундаж утгыг олбол 11.2% байна.

Бусад асуултуудын дүнгээр ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү өснө, төгрөгийн ханш суларна гэсэн иргэдийн хүлээлт өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал эрс өсч судалгаанд оролцогчдын тал хувийг нь эзлэх болжээ. Мөн судалгаанд оролцогчдын ирэх 12 сард хадгаламжинд мөнгөө байршуулахад тохиромжгүй гэсэн хүлээлт өсөх хандлагатай болсон байна. Өрхийн санхүүгийн талаар асуухад судалгаанд оролцогчдын 4 хүн тутмын нэг нь ирэх 12 сард өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн бөгөөд гол шалтгаан нь цалин болон бизнесийн орлого өснө гэж үзжээ.



## 2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нийт 404 аж ахуйн нэгжийг хамруулан судаллаа. Судалгааны үр дүнгээс харахад аж ахуйн нэгж, байгууллагууд 2012 оны эхний улиралд инфляцийн түвшинг **8.9%**, 2012 оны хагас жил, жилийн эцэст **7.9%**-д хүрнэ гэж хүлээж байна.

### Хүснэгт 2.1 Аж ахуйн нэгж /өмчлөдөөр/

Аж ахуйн нэгжийн хэлбэр	тоо	хувь
Нөхөрлөл	3	0.7
Хоршоо	9	2.2
Хувьцаат компани	38	9.4
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	352	87.1
Төрийн өмчийн үйлдвэрийн газар	2	0.5
<b>Нийт дүн</b>	<b>404</b>	<b>100</b>

### 2.1. Түүвэр судалгаанд оролцогчид

Судалгаанд хамрагдсан нийт 404 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 87.1% нь хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани, 9.4% нь хувьцаат компани байлаа /Хүснэгт 2.1/.

### Хүснэгт 2.2 ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ /салбараар/

Салбарын бүлэг	тоо	хувь
Хөдөө аж ахуй	10	2.5
Уул уурхай, олборлох	32	7.9
Боловсруулах үйлдвэр	9	2.2
Барилга	54	13.4
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	77	19.1
Жижиг дунд үйлдвэрлэл	45	11.1
Үйлчилгээ	144	35.6
Тээвэр	33	8.2
<b>Нийт дүн</b>	<b>404</b>	<b>100.0</b>

Үйлчилгээ эрхэлдэг 144 (35.6%), бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 77 (19.1%), барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 54 (13.4%), тээврийн үйлчилгээ эрхэлдэг 33 (8.2%) болон уул уурхай, олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 32 (7.9%) аж ахуйн нэгжийг хамруулаа /Хүснэгт 2.2/.

### Хүснэгт 2.3 ААН-ийн салбарын бүлэг /ажилчдын тоогоор/

Салбарын бүлэг	Ажиллагчдын тоо /бүлгээр/				Бүгд
	≤10	11-50	51-100	100≤	
Хөдөө аж ахуй	6	3	0	1	10
Уул уурхай, олборлох	5	20	3	4	32
Боловсруулах үйлдвэр	2	3	3	1	9
Барилга	12	26	8	8	54
Б/Ж худалдаа	49	22	2	4	77
Жижиг дунд үйлдвэрлэл	24	15	6	0	45
Үйлчилгээ	92	41	6	5	144
Тээвэр	16	14	3	0	33
<b>Нийт дүн</b>	<b>206</b>	<b>144</b>	<b>31</b>	<b>23</b>	<b>404</b>


Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг ажилчдын бүлгээр авч үзвэл 10 болон түүнээс бага ажилчинтай<sup>6</sup> 206 (50.9%), 11-ээс 50 хүртэлх ажилчинтай 144 (36.5%), 51-ээс 100 хүртэлх ажилчинтай 31 (7.7%), болон 100-аас дээш ажилчинтай 23 (5.7%), аж ахуйн нэгж хамрагдлаа /Хүснэгт 2.3/.

<sup>6</sup> Тогтмол хөдөлмөр эрхэлдэг ажилчинтай


## 2.2. Үнийн ерөнхий түвшний хүлээлт

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан 2011 оны 12-р сарын инфляцийн хүлээлтийн санал асуулгыг явуулахдаа чанарын болон тоон хариултыг авах замаар 2 аргачлалаар хүлээлтийг тооцсон болно.

**Зураг 2.1 ААН-ийн инфляцийн хүлээлтийн чанарын хариулт**



**Зураг 2.2 ААН-ийн инфляцийн хүлээлтийн чиглэлийн индекс**



Санамж: Чиглэлийн индекс нь (-1;3) завсарт утгаа авна. Нэмэх чиглэл руу хүлээлтийн хандлага өссөн, хасах чиглэл руу инфляцийн хүлээлтийн хандлага буурсан байгааг илтгэнэ.


### Үнийн ерөнхий түвшин /чанарын хариулт/

Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны үндсэн асуулт болох “Танай компанийн түүхий эд болон бусад бараа материалд төлж байгаа үнэ ирэх 12 сард хэрхэн өөрчлөгдөнө гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудын 60.1% нь үнийн түвшин ерөнхийдөө өснө гэсэн нь өмнөх судалгааны дүнгээс даруй 11.0 нэгж хувиар буурсан үзүүлэлт байлаа /Зураг 2.1/. Түүнчлэн үнэ хурдацтай өснө буюу инфляци өснө гэж хариулсан ААН, байгууллагуудын хувь өмнөх судалгааны дүнгээс 18.2 нэгж хувиар буурч 2011 оны 1-р сар, 2009 оны 3-р сарын түвшинд очсон байгаа нь үнэ өсөх хүлээлт буурсан байгааг харуулж байна.

Чиглэлийн индексээс харахад 12 сарын дараах үнийн хүлээлт 2012 оны 1-р сарын байдлаар өмнөх судалгааны дүнгээс огцом буурчээ /Зураг 2.2/. ААН-үүдийн инфляцийн хүлээлт ийнхүү буурсан нь шатахууны үнэ огцом өссөн үеийнхээс буурна гэж үзэж байгаатай холбоотой байж болно.

Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлал (Carlson-Parkin method)-аар тоон үзүүлэлт рүү шилжүүлэн тооцоход аж ахуйн нэгж, байгууллагын түүхий эд болон бусад бараа материал, үйлчилгээнд төлж байгаа хүлээгдэж буй инфляцийн түвшин 2012 оны 1-р улиралд **8.9%**, 2 болон 4-р улирлын эцэст ижил буюу **7.9%** байхаар хүлээгдэж байна. Өөрөөр хэлбэл, түүвэр судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд **инфляцийн түвшин 2012 оны 2-р улирлаас эхлэн буурна** гэж үзжээ.


Зураг 2.3 ААН-ийн 12 сарын дараах үнийн өсөлтийн түвшин /харьцангуй давтамж/




### Үнийн ерөнхий түвшин /тоон хариулт/

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудын 12 сарын дараах инфляцийн хүлээлтийн түвшинг тодорхой тоон утгаар асуух замаар санал асуулгын үр дүнг нэгтгэн тооцлоо /Зураг 2.3/. Үр дүнгээс харахад 12 сарын дараах хүлээгдэж буй инфляцийн түвшин **11.2%**-тай байна.

Зураг 2.4 ААН-ийн өнгөрсөн 6 сар дахь эрэлт /бараа бүтээгдэхүүн/



Зураг 2.5 ААН-ийн ирэх 6 сарын эрэлт




### 2.3. Бусад хариулт

#### Бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн болон үйлчилгээний эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар асуухад санал асуулгад оролцогчдын 38.4% нь өссөн, 44.1% нь өөрчлөгдөөгүй, 17.6% нь буурсан гэж хариулсан нь өмнөх оны мөн үеийн судалгааны дүнтэй харьцуулахад эрэлт өссөн гэсэн хариултын хувь 2.2 нэгж хувиар буурч, харин буурсан гэсэн хариулт 4.4 нэгж хувиар өссөн дүн байлаа. Энэ нь **иргэдийн худалдан авалт өмнөх оны мөн үеийнхээс бага зэрэг буурсныг илтгэж байна** /Зураг 2.4/.


Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирэх 6 сарын хугацаанд бараа болон бүтээгдэхүүний хүлээгдэж буй эрэлтийн түвшний талаар асуухад 39.9% нь өснө, 29.2% нь өөрчлөгдөхгүй, 12.4% нь буурна гэж хариулсан байна. Өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад өснө гэсэн хариулт 2011 оны 1, 6-р саруудынхаас харгалзан 7.0, 3.2 нэгж хувиар буурч, буурна гэсэн хариултын хувь харгалзан 2.7, 3.9 нэгж хувиар өссөн нь ААН-үүдийн **эрэлт өснө гэсэн хүлээлт бага зэрэг буурсан байгааг харууллаа** /Зураг 2.5/. Дундаж дүнгээр эдийн засаг өсч байгаа хэдий ч ядуурал, тэгш бус байдал доривтой сайжирахгүй байгаа нь эрэлт өсөх хүлээлтийг нэмэгдэхгүй байхад нөлөөлж байж болох юм.

**Зураг 2.6 ААН байгууллагуудын ажлын байр ирэх 6 сард**




Санамж: 2009 оны 3,9-р сарын судалгаанд ирэх 3 сарын талаар асуусан болно

**Зураг 2.7 ААН байгууллагуудын цалин ирэх 6 сард**



Санамж: 2009 оны 3,9-р сарын судалгаанд ирэх 3 сарын талаар асуусан болно

**Зураг 2.8 ААН байгууллагуудын ирэх 6 сар дахь цалингийн дундаж өсөлт**



Санамж: 2009 оны 3,9-р сарын судалгаанд дараа ирэх 3 сарын талаар асуусан болно

**Хүснэгт 2.4 ААН-ийн ажлын байр, цалингийн өсөлт**

Ирэх сард ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?	Ирэх 6 Сард цалингаа өсгөх үү?		
	Тийм	Үгүй	Нийт дүн
Нэмэгдэнэ	22.8%	14.4%	37.1%
Өөрчлөгдөхгүй	25.5%	31.9%	57.4%
Буурна	1.0%	4.5%	5.4%
<b>Нийт дүн</b>	<b>49.3%</b>	<b>50.7%</b>	<b>100.0%</b>

**Ажил эрхлэлт, цалин**

Судалгаанд оролцогч ААН, байгууллагуудаас ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх талаар асуухад санал асуулгад оролцогчдын 150 нь буюу 37.1% нь нэмэгдэнэ гэж хариулсан нь 2011 оны 6-р сарын судалгааны дүнгээс 6.8 нэгж хувиар өссөн бол 2011 оны 1-р сарын дүнгээс 6.0 нэгж хувиар буурсан дүн байлаа. Судалгаа явуулсан хугацааны ерөнхий хандлагаас харахад **ажлын байр нэмэгдэх хандлагатай байна.**


“Ирэх 6 сард танай компани цалин хөлсөө нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна уу?” гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан ААН, байгууллагуудын 49.3 хувь нь нэмэгдэнэ гэж хариулжээ. Энэ нь 2011 оны 6-р сарын дүнгээс 10.3 нэгж хувиар өссөн 2011 оны 1-р сарын дүнгээс 2.0 нэгж хувиар буурсан дүн байна. Ажлын байр нэмэгдэх хандлагатай байгаагийн дээр **цалин хөлсөө нэмэгдүүлэх аж ахуйн нэгжийн тоо ч бас нэмэгдэх хандлагатай байна.**

Цалингийн түвшингээ ирэх 6 сард нэмэгдүүлнэ гэж хариулсан ААН-ээс цалингийн түвшингээ хэд хүртэл хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгааг нь тодруулахад дунджаар 15.9%-иар нэмэх төлөвлөгөөтэй байна /Зураг 2.8/. Өмнөх судалгааны дүнгээс 1.2 нэгж хувиар илүү байгаа нь төрийн захиргааны албан хаагчдын цалинг 80 мян.төгрөгөөр буюу 2011 оны эцсийн дундаж цалингийн 17.6%-тай тэнцэх хэмжээгээр нэмэх болсонтой холбоотой байж болно.

Түүнчлэн ажлын тоогоо нэмэгдүүлж, ирэх 6 сард цалингаа нэмэгдүүлэхээр төлөвлөж буй нийт 92 (22.8%) ААН байна. Харин ажилчдын тоондоо өөрчлөлт оруулахгүйгээр цалингаа нэмэгдүүлэх 103 (25.5%), цалингаа өсгөхгүй байх 205 (50.7%) ААН байна /Хүснэгт 2.4/.

Түүвэр судалгааны санал асуулгын үр дүнгээс харахад ойрын хугацаанд шинэ ажлын байр нэмэгдэх магадлал ихэсч байгаа бөгөөд, ихэнх аж ахуйн нэгж ирэх 6 сард ажилчдын цалингаа нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.


Зураг 2.9 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр



Хүснэгт 2.5 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр /ажилчдын тоогоор/

Санхүүжилтийн хэлбэр	Ажилчдын тоо				Бүгд
	<10	11-50	50-100	100<	
Банкны санхүүжилтээр	24.8%	15.3%	2.5%	1.2%	43.8%
Компаны өөрийн хөрөнгөөр	19.8%	13.2%	5.0%	2.1%	40.1%
Хувьцаа гаргах	1.2%	3.3%	0.4%	0.0%	5.0%
Гадаад эх үүсвэрээр	2.9%	3.7%	0.0%	0.4%	7.0%
Санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	1.2%	1.7%	0.0%	0.4%	3.3%
Тэтгэлэг тусламжаар	0.8%	0.0%	0.0%	0.0%	0.8%
Нийт дүн	50.8%	37.2%	7.9%	4.1%	100.0%

Хүснэгт 2.10 ААН-ийн ирэх 6 сарын зээлийн хэрэгцээ



Санхүүжилт болон зээл

Санал асуулгад оролцсон ААН, байгууллагуудаас “Ирэх 6 сарын хугацаанд компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна уу?” гэж асуухад 59.9% нь тийм, 40.1% нь үгүй гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад тийм гэсэн хариулт 7.4 нэгж хувиар өсчээ. Өргөжүүлэх төлөвлөгөөтэй дээрх ААН, байгууллагуудаас ямар эх үүсвэрээр компаниа өргөжүүлэх талаар асуухад 40.7% нь банкны, 40.3% нь компанийн өөрийн хөрөнгөөр санхүүжинэ гэсэн бол гадаад эх үүсвэр, хувьцаа гаргах, бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр, тэтгэлэг тусламжаар санхүүжих ААН-үүд 1.3%-9.5% хооронд байна. Эндээс үзэхэд банкнаас болон өөрийн хөрөнгийн санхүүжилт дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна.


Түүнчлэн бичил бизнес<sup>7</sup> эрхлэгчдийн 48.8% нь банкны санхүүжилтээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бол жижиг дунд бизнес<sup>8</sup> эрхлэгчдийн хувьд уг үзүүлэлт 41.1%-тай байна /Хүснэгт 2.5/. Түүвэр судалгааны дүнгээр бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь тодорхой хэмжээний банкны зээлийн хэрэгцээ шаардлагатай байгаа нь харагдлаа.

Аж ахуйн нэгжээс “Ирэх 6 сард танай компанийн зээлийн хэрэгцээ хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэж асуухад 46.3% нь нэмэгдэнэ, 48.5% нь өөрчлөгдөхгүй, харин 5.2% нь буурна гэж хариулсан байна /Зураг 2.10/. Үүнийг өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулахад зээлийн хэрэгцээ нэмэгдэнэ гэж хариулсан аж ахуйн нэгжийн тоо хагас жилийн өмнөхөөс даруй 10.5, өмнөх оны мөн үеэс 3.7 нэгж хувиар өсчээ.


<sup>7</sup> Үндсэн ажилчдын тоо 10-аас бага

<sup>8</sup> Үндсэн ажилчдын тоо 11-50 хүртэлх

Зураг 2.11 ААН-ийн ханшийн түвшний хүлээлт



Зураг 2.12 ААН-ийн 12 сарын дараах ханшийн түвшин



### Ханшийн хүлээлт

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс “Төгрөгийн бусад валютуудтай харьцах ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэж асуухад 2012 оны 1-р улиралд төгрөгийн ханш чангарна гэж 41.6%, 2-р улиралд 37.3%, 4-р улиралд 35.3% нь хариулж төгрөгийн ханш чангарна хүлээлт суларсан байна /Зураг 2.11/. АНУ-д ажил эрхлэлт зэрэг үзүүлэлтүүд сайжирсан, Европын эдийн засагт тулгараад байгаа асуудлууд бүрэн шийдэгдээгүй байгаа зэргээс ам.долларын ханш дэлхийн зэхзээл дээр чангарна хандлагатай болсон нь ийнхүү хүлээлт үүсгэхэд нөлөөлсөн байж болно.

Мөн өмнө хийсэн судалгаатай харьцуулахад 2012 оны эхний хагаст төгрөгийн ханш чангарна гэсэн хариулт даруй 11.1%-иар буурч суларна гэсэн хариулт 3.5 хувиар өссөн байна. Үүнээс үзэхэд ААН, байгууллагуудын дунд **төгрөгийн ханш суларна гэсэн хүлээлт нэмэгдсэн байна.**


### ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр аж ахуйн нэгж, байгууллагууд инфляцийн түвшинг 2012 оны эхний улиралд **8.9%**, 2012 оны хагас жил, жилийн эцэст **7.9%** байна. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжүүд инфляцын эрч оны эхний хагасаас саармагжина гэж үзжээ. Ажиллах хүчний захзээлд ойрын хугацаанд ажлын байр нэмэгдэх хандлагатай байгаа ба ажиллагсдынхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгууллагуудын тоо өссөн байна. Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагуудад ойрын ирээдүйд үйл ажиллагаа явуулах болон өргөжүүлэхэд нь санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай байгаа нь түүвэр судалгааны үр дүнгээс харагдсан ба санхүүжилт шаардлагатай байгаа аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь нь банкаас санхүүжүүлгээ авах сонирхолтой байна. Төгрөгийн ханш цаашдаа суларна гэсэн хүлээлт ААН-үүдийн дунд нэмэгджээ.

### 3. ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн судалгаанд арилжааны банк, хөгжлийн банк, их сургууль болон судалгааны төвд ажилладаг нийт 10 шинжээч оролцов. Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (инфляци, нийт мөнгөний өсөлт, төгрөгийн ханш, ДНБ-ий өсөлт, цалин)-ийг багтаасан бөгөөд хариултыг шууд тоон үзүүлэлтээр авч, шинжээчдийн таамгуудын жигнэсэн дунджаар хүлээлтийг тооцоолов. Судалгааны дүнгээс харахад шинжээчид жилийн инфляци 2012 оны 1-р улиралд **12.4%**, эхний хагас жилд **12.6%**, оны эцэст **13.1%** болохоор таамаглаж байна.

Зураг 3.1 Инфляци




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийн харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

#### 3.1. Инфляци

Шинжээчдийн таамгаар жилийн инфляци 2012 оны 1-р улиралд 12.4%, 2 ба 3-р улиралд 12.6 ба 12.7%, оны эцэст 13.1% байхаар тус тус хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 1-р улирлын инфляцийн хүлээлт 2.3 нэгжээр буурсан байна. Шинжээчдийн таамгаас харахад инфляци 2012 оны турш дунджаар 12-13%-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд хамгийн өндөр хүлээлттэй нь 1-р улиралд 20.1%, хамгийн бага хүлээлттэй нь 7.2% байхаар таамаглажээ /Зураг 3.1/.

Зураг 3.2 Нийт мөнгөний өсөлт /M2/




Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

#### 3.2. Нийт мөнгөний өсөлт /M2/

Шинжээчид M2 мөнгөний жилийн өсөлт 2012 оны эхний хагас жил хүртэл тогтмол өсч, 3-р улиралд буураад 4-р улиралд эргэн өсч 45.3%-д хүрнэ гэж тооцоолж байна. 1-р улиралд 44.4%-иар өсөхөөр таамагласан нь өмнөх судалгаатай харьцуулахад 27.0 нэгжээр буурчээ. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны 2-р улиралд мөнгөний нийлүүлэлт жилийн 69.6%-иар, хамгийн бага хүлээлттэй нь 20.7%-иар өснө гэж тус тус таамаглаж байна /Зураг 3.2/.

**Зураг 3.3 Төгрөг/долларын ханш**




Эх сурвалж: Монголбанк  
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

**3.3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш**

Шинжээчид төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 1-улиралд бага зэрэг суларч 1339.8 төгрөг болохоор таамагласан нь өмнөх судалгаатай харьцуулахад 77 төгрөг буюу 6.3%-иар өссөн байна. Харин 2-р улирлаас эхлэн ханш тогтмол чангарч, эхний хагас жилд 1309.5 төгрөг, оны эцэст 1290.7 төгрөг болохоор тус тус таамаглажээ. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлтэй нь 1-р улиралд төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 1450.0 төгрөг, хамгийн бага хүлээлтэй нь 1208.7 төгрөг байхаар тус тус төсөөлж байна. /Зураг 3.3/.

**Зураг 3.4 Төгрөг/юаны ханш**




Эх сурвалж: Монголбанк  
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

**3.4. Төгрөгийн юаньтай харьцах ханш**

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 2012 онд бага зэрэг чангарах бөгөөд 1-р улиралд 213.4 төгрөг, эхний хагас жилд 207.8 төгрөг, оны эцэст 205.6 төгрөг байхаар хүлээгдэж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад юаны ханшийн хүлээлт 1-р улиралд 22.4 төгрөг буюу 11.7%-иар өссөн байна. Шинжээчдийн таамгаас хамгийн өндөр хүлээлтэй нь 1-р улиралд ханш 250.0 төгрөг, хамгийн бага хүлээлтэй нь 3-р улиралд 190.2 төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.4/.

**Зураг 3.5 ДНБ-ий өсөлт**




Эх сурвалж: Монголбанк  
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

**3.5. ДНБ-ий өсөлт**

Шинжээчид бодит ДНБ-ий өсөлт 2012 оны 1-р улиралд 15.3%, 2-р улиралд 19.5%, 3-р улиралд 21.5%, жилийн эцэст 19.9% болохоор тус тус таамаглаж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 1 улирлын хүлээлт 4.8%-иар өссөн байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлтэй нь 2012 оны 3-р улиралд ДНБ-ий өсөлт 35.1%, хамгийн бага хүлээлтэй нь 1-р улиралд 8.0% байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.5/.



Зураг 3.6 Сарын дундаж нэрлэсэн цалин



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

### 3.6. Сарын дундаж нэрлэсэн цалин

Шинжээчдийн таамгаар сарын дундаж нэрлэсэн цалин тогтмол өсч, 1-р улиралд 473 мянган төгрөгт хүрэх бөгөөд 2-р улиралд 8.9%-иар, 3-р улиралд 6%-иар, 4-р улиралд 7.3%-иар тус тус нэмэгдэж оны эцэст 585.7 мянган төгрөгт хүрнэ гэж тооцоолж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад 1-р улирлын хүлээлт 22 мянган төгрөг буюу 4.9% иар өссөн байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2012 оны эцэст сарын дундаж нэрлэсэн цалин 668.0 мянган төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 1-р улиралд 420.3 мянган төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.6/.

## ДҮГНЭЛТ

Шинжээчдийн таамгаас харахад 2012 онд инфляци 12-13%-ийн хооронд байхаар хүлээгдэж байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 3-р улиралд бага зэрэг буурч бусад үед өсөх бөгөөд дунджаар 46 орчим хувийн өсөлттэй байх таамагтай байна. Бодит ДНБ-ий өсөлт 1 ба 4-р улиралд бага зэрэг буурах ч ерөнхий хандлага нь өсөх бөгөөд оны эцэст 19.9% байхаар тооцоолжээ. Төгрөгийн ам.доллартай харьцах болон юаньтай харьцах нэрлэсэн ханш тогтмол чангарахаар хүлээгдэж байна. Нэрлэсэн цалин тогтвортой өсөхөөр таамаглаж байна.

Хавсралт 1. Санал асуулгад оролцсон иргэдийн ерөнхий мэдээлэл (хувиар)										
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX
		2008-12 сар	2009-09 сар	2010-01 сар	2010-07 сар	2011-01 сар	2011-03 сар	2011-06 сар	2011-09 сар	2012-1 сар
Санал асуулга явуулсан огноо		1046	1000	1015	1000	1006	1030	1058	1023	1036
Нийт асуулгад оролцсон иргэдийн тоо		1046	1000	1015	1000	1006	1030	1058	1023	1036
Хүйс	Эрэгтэй	43.2	36.8	39.4	37.3	37.2	34.3	37.5	36.3	36.4
	Эмэгтэй	55.0	63.2	60.6	62.7	62.8	65.7	62.5	63.7	63.6
	Нийт	98.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Нас	18-24	31.2	21.2	19.6	25.4	24.5	28.3	21.5	22.6	19.8
	25-34	22.7	26.8	28.0	30.9	33.2	28.6	32.1	27.7	29.1
	35-44	19.9	25.1	20.9	21.9	22.9	18.2	23.4	22.9	24.1
	45-54	16.0	17.0	18.2	14.1	12.9	14.1	13.3	15.7	15.3
	55-аас дээш	10.3	9.9	13.3	7.7	6.6	10.8	9.6	11.1	11.7
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсрол	Дээд	50.7	49.6	60.3	52.4	49.8	47.7	46.6	42.6	45.1
	Бүрэн дунд	36.3	40.2	31.1	39.6	37.6	40.8	39.4	45.9	41.6
	Бүрэн бус дунд	9.6	8.3	8.0	7.6	10.4	10.0	12.6	10.5	11.8
	Бага	2.3	1.1	.5	.2	1.1	1.4	1.2	.7	1.2
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ам бүлийн тоо	1	4.4	2.3	3.0	3.7	4.9	5.7	6.7	4.1	3.5
	2-3	33.8	36.9	36.8	38.6	39.5	34.1	43.4	40.1	36.9
	4-5	45.3	46.7	43.0	43.6	41.8	46.6	41.7	41.7	45.1
	5-аас дээш	16.6	14.1	17.2	14.1	13.8	13.6	8.2	14.1	14.6
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажил эрхлэлт	Төрийн алба	15.8	16.2	13.2	14.7	12.7	14.5	16.8	17.7	17.5
	Хувиараа	26.9	26.2	27.2	27.1	30.6	28.3	32.2	27.7	23.7
	Хувийн байгууллага	19.2	22.8	25.5	34.2	31.4	21.5	27.4	20.2	23.5
	Төрийн бус байгууллага	5.5	4.6	6.3	4.0	5.1	6.2	4.5	5.1	4.2
	Гадаадын байгууллага	-	-	-	-	-	-	-	1.5	.5
	Цагийн ажил	5.1	2.4	1.6	2.8	2.4	3.0	3.0	3.8	3.4
	Ажилгүй	-	24.3	24.8	16.0	17.8	26.6	16.0	24.0	27.3
	Тэтгэвэрт	27.4	2.7	1.4	1.2	-	-	-	-	-
Нийт	100.0	99.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Өрхийн орлого	100 мянгаас бага	14.5	9.5	10.7	7.5	-	-	-	-	-
	101-200 мянга	22.4	21.6	20.1	16.2	-	-	-	-	-
	201-300 мянга	24.9	26.6	22.9	25.7	-	-	-	-	-
	301-400 мянга	17.9	19.9	17.7	21.8	-	-	-	-	-
	401-500 мянга	11.1	9.8	12.2	13.7	-	-	-	-	-
	500 мянгаас дээш	9.2	9.9	16.4	15.1	-	-	-	-	-
Нийт	100.0	93.7	100.0	100.0	-	-	-	-	-	
Өрхийн орлого*	200,000 төгрөгөөс доош	-	-	-	-	22.2	25.9	20.7	17.8	12.9
	200,001-400,000 төгрөг	-	-	-	-	28.5	33.8	30.0	28.5	34.3
	400,001-600,000 төгрөг	-	-	-	-	25.1	23.2	26.3	27.5	26.1
	600,001-800,000 төгрөг	-	-	-	-	13.7	9.3	14.6	14.9	12.4
	800,001-1,000,000 төгрөг	-	-	-	-	5.8	4.7	3.7	6.4	7.6
	1,000,000 төгрөгөөс дээш	-	-	-	-	4.7	3.1	4.8	5.0	6.8
Нийт	-	-	-	-	100.0	100.0	100.0	100.0	100.0	

